



СОЛОНГОС ХЭЛНИЙ ДӨРВӨН ҮСЭГТ ХЭЛЦИЙГ ОРЧУУЛАХ ТУХАЙД

Я.Ренчинпүрэв³⁶, С.Чулуунбат³⁷

간략한 내용: 현대까지 한국과 몽골 양국의 학자들이 지혜와 지식을 다해서 서로의 역사와 정치 사회와 경제 그리고 언어 등 여러 분야의 연구를 해 왔다. 이번 연구에서는 한국어와 몽골어 그 중에서도 한국어의 은유적 표현인 사자성어의 몽골어 번역에 대해 알아보려고 한다. 그동안 몽골과 한국 연구자들은 한국어의 은유적 표현 중에서 속담, 관용어 그리고 속어에 대한 비교적 대조적인 연구를 많이 했다. 언어의 은유적 표현을 잘 분석하면 할 수록 언어적 가치가 있을 뿐만 아니라 문화적 가치가 있다. 은유적 표현 속에는 그 언어를 쓰는 사람들의 세계관과 문화적 가치가 담겨져 있기 때문이다.

Түлхүүр үг: Солонгос хэлний дөрвөн үсэгт хэлц; хэллэг; орчуулга; хичээл зүтгэл; ертөнцийг үзэх үзэл; дүйцэл, утга санаа, ойлголт

Хүн төрөлхтөн юмыг таньж мэдэхдээ сэрж мэдрэх, сэтгэж ухаарах гэсэн хоёр үндсэн аргатай. Ертөнцийн юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарыг харах, сонсох, үнэрлэх, амтлах болон хүрэлцэх мэдрэхүй нь анхдагч, харин түүний суурин дээр хийсвэрлэн сэтгэх, ухаарч ойлгох, улмаар түүний тухай оюун дүгнэлт хийж, уг юмны тухай цогц мэдлэгтэй болох нь хоёрдогч шат болно.

Шинээр танин мэдэж, шинээр бүтээн бий болгосон зүйлсээ хэлээр илэрхийлэх, нэрлэх хэрэгцээ шаардлага бий болж, түүнийгээ “шууд” ба “шууд бус” гэсэн хоёр үндсэн аргаар шинээр нэрлэдэг. Ингэхдээ хоёр юмыг өөр хооронд нь жишин харьцуулж, шинээр нэрлэх гэж байгаа юмаа түүнтэй хамгийн ойр төсөөтэй мэддэг зүйлийнхээ шинжээр адилсуулан (analogy) нэрлэх аргыг хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, шууд бус шинэ нэрлэлт нь тухайн хэлэндээ байгаа бэлэн үг хэллэгийг найруулгын дүрслэх ур маягаар хувиргаж холбоо үг, хоршоо үг, зүйрлэсэн хэллэг, өвөрмөц хэллэг, хэвшмэл хэллэгийн зүйлийг үүсгэдэг зүй тогтолтой байна. Түүнчлэн шууд нэрлэлт үнэлэмжийн утгагүй байдаг бол шууд бус нэрлэлт нь заавал үнэлэмжийн утгатай байдаг аж. Ингэж шууд бус нэрлэлт үүсгэх нь танин мэдэхүйн хязгааргүй шинж ба хэлний үгийн сангийн “хязгаарлагдмал” шинж хоёрын тэнцвэрийг хадгалах хамгийн зохистой арга боломж юм гэж үзэж болно.

Гэвч юуг юутай адилсуулах нь өөр өөр соёл-хэлтэнд нийтлэг бас ялгаатай байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн соёл-хэлтний ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан онцлогоос шалтгаалж, юмс үзэгдэл, үйл явдал, шинж чанарын тухай сэтгэлгээний тогтсон хэв шинж, жишиг хэмжүүр бий болдог байна.

³⁶ МУИС, ШУС, магистрант

³⁷ Ph.D, МУИС, ШУС, Ази судлалын тэнхим

Сэтгэлгээний тогтсон хэв шинж, тогтсон жишиг хэмжүүр нь тухайн соёл-хэлтэн юмс үзэгдэл, үйл явдал, байдал нөхцөл, шинж чанарыг үнэлсэн үнэлэмж нь байдаг. Энэ үнэлэмж нь адилтгал зүйрлэлээр илэрнэ. Ингэж үндэстний уламжлалт аж амьдарлагын онцлогоос үүдэлтэй, үндэстний сэтгэлгээг тодорхойлогч элдэв зүйрлэсэн хэллэг үүсэж хэрэглэгддэг.

Тодорхой нэг хэлний утгазүйн судалгаанд метафор бол сэтгэхүйн үндсэн үйл ажиллагаа, ертөнцийг танин мэдэх, тайлбарлах, бүтэцлэх арга юм гэх бөгөөд хүн метафорын тусламжтайгаар өөрийн санааг илэрхийлдэг. [Төмөрхуяг, 2011] гэж үздэг ажээ. Метафорыг голлох чиг хандлагуудын нэг нь АНУ-д үүссэн танихуйн хэл шинжлэл бөгөөд Ж. Лакофф, М. Жонсон, Р. Лангакер, Л. Талми, У. Чейф, Р. Жэкендофф, М. Тернер, Ч. Фильмор, Ж. Фоконье нарын бүтээл энэ төрлийн судалгааны онол-аргазүйн үндэс суурь болдог байна. Тэгвэл танихуйн хэлшинжлэл үүсэн хөгжих ойролцоо цаг үед Оросын хэлшинжлэлд метафор зэрэг хэлний илэрхийллийг тухайн хэлээр харилцагч үндэстний ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньж мэдсэн ухаарал ойлголт, мэдлэгийн баримт гэж үзэн, зүйрлэсэн хэллэгийн үндэс, үр дүн, үйл явцыг хүн төвт үзэл (anthropocentric) хандлагын үүднээс тайлбарлан судалдаг хэл, орон судлал (лингвострановедение), хэлний соёл судлал (лингвокультурология), угсаа хэлшинжлэл (этнолингвистика) зэрэг шинэ чиг хандлага бий болж, хөгжсөөр иржээ.

“Бодит ертөнц”, “хийсвэр ертөнц” хэмээх гүн ухааны нийтлэг үндэслэлтэй уялдаж, сэтгэхүй, хэлний харилцан хамаарлын мөн чанарын судалгаанд “ертөнцийн дүр зураг”, “ертөнцийн тухай хэлний дүр зураг” [Серебренников, 1988] гэсэн томъёолол хэрэглэгдэх болсон нь хэлний адилтгал үүсэх арга зарчим, түүний харилцааны болон тэмдгийн үүргийг тайлбарлахад ихээхэн учир холбогдолтой болж байна. Мөн бодит ертөнц, хийсвэр ертөнц хоёрын дунд “боломжит ертөнц” байх боломжтой гэж үздэг. Хэлний адилтгал зүйрлэл, түүний суурин дээр үүсдэг өвөрмөц хэллэг зэрэг тогтвортой нэгжүүд нь бидний ойлгож буйгаар энэхүү гурван ертөнцийн тусгал-тэмдэглэхүүн болдог гэж ерөнхийлөн хэлж болно.

Монгол **зүйр цэцэн үгийг** аман зохиолын бие даасан төрөл зүйл мөн гэх талаас нь судлан тодорхойлсон болон монгол зүйр цэцэн үгийг цуглуулж эмхэтгэсэн байдлыг авч үзвэл, Б. Содном (1935), Н. Дамбасүрэн (1950), Л. Мишиг, Б. Содном нар (1956), Б. Ринчин (1959), Ж. Дашдорж, Г. Ринчэнсамбуу нар (1964), П. Хорлоо (1966), John Krueger, Хангины Гомбожав нар (1967), Ш. Гаадамба (1969), Г. Л. Пермяков (1979), Г. Эрдэнэ-Очир (1983), Ш. Гаадамба, Х. Сампилдэндэв, Д. Цэрэнсодном нар (1988), Д. Заяабаатар (1999), Г. Аким (2001), Ж. Төмөрцэрэн (2001), Чой. Лувсанжав (2006), С. Дулам, Г. Нандинбилиг нар (2007), Н. Ням-Осор, Б. Өлзийсүрэн (2011) нарын эрдэмтэн судлаачид тус тусын судалгааны үр дүн, бүтээлээ хэвлүүлжээ. Тэдний бүтээлийг бүтэц агуулгаар нь ерөнхийд нь багцалж тэмдэглэвэл, монгол ардын зүйр цэцэн үгсийг дээжлэн эмхэтгэснээс гадна бүтээх арга журам, зохиомжийнх нь онцлогийг харгалзан харилцан адилгүй ангилсан байдаг.

Монгол зүйр үгийн тухайд Гаадамба, Х. Сампилдэндэв, Д. Цэрэнсодном нар “Монгол ардын аман зохиол” (1988) хэмээх хамтын бүтээлдээ, *“Зүйр цэцэн үг бол хүний аж төрөлд нийгмийн чиг баримжаа, мөрдлөг болгох зорилгоор ард түмний нийгмийн аж төрөл, хөдөлмөр тэмцлийн аль нэг талын түүхэн туршлагыг цөөвөр үгээр туйлын товч оновчтой, уран хурцаар илэрхийлсэн тогтмол бүтэцтэй үг хэллэг мөн”* хэмээн тэмдэглээд, зүйр үг, цэцэн үг, мэргэн үг гэх мэтээр тус тус ангилжээ.

Түүнчлэн С. Дулам, Г. Нандинбилиг нар “Монгол аман зохиолын онол Г” (2016) бүтээлдээ “Ихэнх зүйр цэцэн үг шилжсэн утгатай байдаг буюу далд утгатай болдгийг дурдах учиртай. Бидний ажиглалтаар бас цэцэн үг нь голдуу шууд утгатай, зүйр үгс нь шилжсэн утгатай байх нь элбэг. ...

Зүйр цэцэн үгийг шинжлэн үзэхэд юуны өмнө бүтээсэн ард түмнийхээ ахуй байдал, зан суртахуун, ёс заншил болон бусад онцлогийг тод тусгасан байдаг” хэмээн тодорхойлохын сацуу, Ш. Гаадамба (1988) нарын зүйр үг, цэцэн үг, мэргэн үг гэсэн ангиллыг дэмжин дурдаад, "Цэцэн үг шинжлэх ухааны маягаар юмны шинж чанарыг тодорхойлж байхад зүйр үг уран зохиолын маягаар нэг юмыг нөгөөгөөр дамжуулан илэрхийлж байдгаараа ялгаатай. Цэцэн үг гүн утга, цэцэн санааг гол болгодог бол зүйр үг нь дүр дүрслэл уран санааг гол болгоно" хэмээн дүгнэжээ.

Монгол зүйр цэцэн үгийг судалсан бас эмхэтгэн тайлбар бичсэн судлаачдын олонх нь зүйр цэцэн үгийг орос хэлний "поговорка и пословица" гэдэг илэрхийлэлтэй нэг төрлийн илэрхийлэл гэж үзээд, "фразеологи" буюу "хэлц судлал" хэмээх салбар ухааны хүрээнд багтаасан байна. Гэтэл Америк, Английн хэлц судлалд бидний "зүйр цэцэн үг" хэмээн нэрлэдэг илэрхийллийг "proverbs" гээд, түүнийг судалдаг ухааныг "хэлц судлал" (phraseology) биш, "зүйр цэцэн үгийн судлал" (paremiology) хэмээн үздэгээрээ ялгаатай байна.³⁸

Харин монгол хэлний хэлц үгийн тухайд судлаач Г.Аким, Бүрэнтөгс, Л.Дашням, Ж.Бат-Ирээдүй нар толилох, зүйлчлэх талаас нь, М.Базаррагчаа бүтэц, утга, хэлбэрийн талаас, Д.Бадамдорж, Ж. Баянсан, Б. Пүрэв-Очир, Б.Баттогтох нар голдуу хэрэглээ, утга, орны талаас, тус тус судалжээ.

Доктор Б. Баттогтох (2006) *"...хэлц нь үгсийн сангийн гол нэгж болох УГ-ээс өргөн, агуулга хэлбэр, бүтэц бүрэлдүүлбэр, илэрхийлэх утга, мэдээлэл хадгалах, дамжуулах үүрэг, яриа бичигт хэрэглэгдэхийнхээ хувьд өгүүлбэртэй адил, тэр ч байтугай ЭХ-ийн түвшинд судалж үзмээр хэлний онцгой нэгж юм."* гэж тодорхойлсон бол профессор Ж. Бат-Ирээдүй *"Тухайн хэлцийг бүтээж байгаа үгсийн үгийн сангийн цөм утга алдран саармагжиж, хэлний утга шалтгаант зүйгээ алдаж, бүхий л үгс нь нийлж нэгэн утга санаа илтгэдэг үгсийг хэлц үг гэж нэрлэж байгаа."* гэж тодорхойлсон байдаг.

Хэлц үгийн утгын ангиллын хувьд судлаач М.Базаррагчаа хүн, амьтан, ургамал, хүний бүтээсэн зүйл, адгуусны бүтээсэн зүйл, гариг ертөнц, сэтгэхүй, мэдрэхүй, зөн билиг, хий үзэгдлийн утга санаа илэрхийлсэн хэлц хэмээн 10 хуваасан бол судлаач Д. Бадамдорж "нэвтрүүлж байгаа санаа, заан илэрхийлж буй утгыг харгалзаж, түүгээр гол шалгуур хийж, агуулгаар нь" монгол амьдрал, хүний сайн үйл, сайхан зүйлийг магтан илэрхийлсэн, монгол амьдрал, хүний муу үйл, муухан явдлыг шүүмжилсэн, хүндэтгэл, бэлгэдэл, ёс зүйн утгатай, муушаал, ёрлол, ёс бусын утгатай, юм, үзэгдэл, чанар хөдөлгөөний ялгавар, чанар шинжийн утгатай хэмээн 5 ангилсан байна.

Энэхүү өгүүллийнхээ хүрээнд солонгос хэлний ханз үсгээр илэрхийлсэн хэлний тогтвортой нэгж гэж үзсэний үндсэнд *"사자성어" (Sajaseong-eo)* буюу *солонгос хэлний дөрвөн үсэгт хэлц үг (Four-Character Korean Idiom)*-ийн орчуулгын талаар авч үзэв. Хэдийгээр ханз үсгээр илэрхийлэгддэг боловч орчин цагийн хятад хэлэнд хэрэглэгдэхээ больсон эртний ханзаар³⁹ бичигдэн хэрэглэгддэг. Жишээ нь: *"여조작비"* буюу <шувуу дэвэлтээ тоолохгүй л бол нисэж чадахгүй> гэх дөрвөн үсэгт хэлцэд орсон *셈 (수)* "тоо,тоолох" гэсэн утгатай *數[shǔ]* ханзыг *数[shǔ, shù, shuò]* гэх мэтээр өөрчлөгдсөн. Тиймээс солонгос хэлний хүрээнд судлах боломжтой гэж үзсэн болно.

Солонгос улсад *"사자성어" (Sajaseong-eo)* буюу солонгос хэлний дөрвөн үсэгт хэлц үгийн судлагдсан байдлын хувьд Kwon Ik (1996), Jeon Hyeon-suk (2001), Kim Mi-young (2004), Lee Gye-yo

³⁸ Т. Эрдэнэ-Очир (2018) "Англи, Монгол хэлний зүйрлэсэн хэллэгийн утгазүйн харьцуулсан судалгаа" доктор (PhD)-ын зэрэг горилсон бүтээл

³⁹ 1956 онд БНХАУ байгуулагдсанаас хойш 9 жилийн хугацаанд уламжлалт хазны зурлагыг хялбаршуулах туйхай хэлэлцэн шинэ (хялбаршуулсан) зурлага зохион 1964-оос БНХАУ ханзны шинэ хувилбарыг ашиглах болсон.

(2002), Ho Chu-wol (2004), Nam Mi-hye (2007), Yo Ji Kang (2010), Beom Hye-mae (2013), He Ren-ka (2017), Huang Shao-xia (2012), Baek Jeong-ok (2017), Son Li-ri (2019), and Jo Suk-jeong (2021) нарын судлаач, эрдэмтэд тус судалгаа хийжээ. Эдгээр судалгааны дийлэнх нь “사자성어” (Sajaseong-eo)-ийн хэлбэр болон утгыг тайлбарлах, ангилах мөн ялгааг тодруулсан бүтээлүүд болсон байна.

Солонгос толь бичгүүдээс дөрвөн үсэгт хэлц үгийг тодорхойлсныг харвал **“Дөрвөн ханзнаас бүтсэн, тодорхой нэг хэрэг явдлаас үүдэлтэйгээр бий болсон нь элбэг, сургаалын шинжтэй, тогтсон хэлбэр бүтэц бүхий хэвшмэл хэллэг нөгөөтээгүүр мэргэн үг”**⁴⁰ хэмээжээ.

Солонгос хэлний дөрвөн үсэгт хэлцийг үүсэл гарлын хувьд

1. Зээлдмэл хэлц: Хятад хэлний ханз хэлц үгийн хэлбэр болон утгыг нь тэр чигээр нь зээлэн хэрэглэдэг.
2. Өөрчлөгдсөн хэлц: Хятад хэлнээс солонгос хэлэнд орж ирсэн ханз хэлц үгийн хэлбэр эсвэл утгын аль нэг нь солонгос хэл, соёлын нөлөөгөөр өөрчлөгдсөн.

Мөн энэхүү өөрчлөгдсөн ханз хэлц үгийг

- a. Хэлбэр нь хятад хувилбартайгаа адил боловч утга нь өөрчлөгдсөн буюу утга өөрчлөгдсөн хэлц,
 - b. Утга нь хятад хэлцтэйгээ адил боловч хэлбэр нь өөрчлөгдсөн буюу хэлбэр өөрчлөгдсөн хэлц гэж хоёр ангилдаг.
3. Уугуул хэлц: Хятад хэлний аль нэг ханз хэлц үгтэй ямар ч хамааралгүй, зөвхөн солонгост үүсэн бий болсон хэлц.⁴¹

Солонгос хэлний ханз үгэнд **зурлага, утга** (тухайн ханз үе, үсэг уугуул солонгос хэлний ямар утгатай дүйх эсэхийг харуулна), **дуудлага** гэсэн гурван чухал бүрэлдэхүүн байна.

사자성어(Sajaseong-eo) буюу солонгос хэлний дөрвөн үсэгт хэлцийн онцлог нь:

1. Зурлагын хувьд уул ханз нь хятадын эртний ханзаар бичигддэг;
2. Тодорхой нэг үйл явдлаас эхтэй байх нь элбэг тохиолддог ба үүслийг нь тайлбарласан домог байдгаараа маш онцлог;
3. Дөрвөн ханзнаас бүтсэн ч өгүүлбэр, эхийн утгыг агуулж байдаг;

Солонгос улсад зохиогдсон дөрвөн үсэгт хэлц үгийн судалгаануудын хувьд ерөнхийдөө хятад хэлний дөрвөн ханзтай хэлц үгтэй харьцуулж судалсан байна. Тухайн судалгаануудыг ангилан авч үзвэл

Нэгдүгээрт: Солонгос-Хятад хэлний дөрвөн үсэгт хэлц үгийн хэлбэр, бүтэц болон утга хийгээд гарлыг харьцуулсан судалгаа;

Хоёрдугаарт: Солонгос хэлний дөрвөн үсэгт хэлц үгээр дамжуулан солонгос хэл сурч буй хятад оюутнуудад солонгос соёлын хичээл заах арга, хэрэглэгдэхүүн боловсруулахтай холбоотой судалгаа;

Гуравдугаарт: Солонгос-Хятад дөрвөн үсэгт хэлц үгийг амьтан, тоо, хүний зан чанартай холбоотой гэх мэтээр ангилаад харьцуулан судалсан судалгаа гэж ангилан үзэж болохоор байна.

Харин манай монгол улсад солонгос хэлний тогтвортой нэгж болох зүйр үг (속담); хэлц үг (관용구); өвөрмөц хэлц (속어); хэвшмэл хэлц (관용어); цэцэн үг (격언); эртний хэлц (고사성어); дөрвөн үсэгт хэлц (사자성어) гэх мэт хэлц хэллэг (은유적 표현)-ийн төрлүүдээс (속담); хэлц үг (관용구); өвөрмөц хэлц (속어); хэвшмэл хэлц (관용어); үгийн талаарх судалгаа, орчуулсан хувилбар багагүй байна. Харин энэхүү өгүүлэлд авч үзсэн **солонгос хэлний дөрвөн үсэгт хэлц хэллэг буюу**

⁴⁰ 국립국어원(1999), 『표준국어대사전』 온라인 공식 홈페이지(www.korean.go.kr)

⁴¹ 사자성어를 활용한 한국문화 교육 방안 연구

사자성어(Sajaseong-eo)-ны хувьд судалгаа шинжилгээ дутмаг байна. Тиймээс уг сэдвийн хүрээнд нэмэлт судалгаа шинжилгээ хийх хэрэгцээ байгаа гэж үзээд уг судалгааны ажлыг эхлүүлсэн болно.

Учир нь солонгос хэлний аль ч чиглэлээр мэргэшиж буй хүн зайлшгүй мэдэж байвал зохих мэдэгдэхүүний нэг бол солонгос хэлний ханз үгийн талаарх мэдлэг билээ. Бүгд Найрамдах Солонгос Улсын Эх хэлний хүрээлэн 2023 оны 12-р сарын статистик мэдээгээр солонгос хэлний толь бичиг дэх нийт үгнээс ярианы хэлний 33.275% ; бичгийн хэлний 59.934%-ийг ханз үг дангаараа эзэлдэг гэсэн үр дүн гарчээ. Мөн түүнчлэн солонгос хэлний ханз үг ба гадаад үг, ханз үг ба уугуул үг, ханз үг ба гадаад үг нэмдэг нь уугуул үг гэх мэтчилэн хавсарч хэрэглэгддэг үгс ч багагүй хувийг эзэлж байдаг. Дэлгэрэнгүйг доорх хүснэгтээр илэрхийлэв.

№	Үгийн төрөл	Ярианы хэл		Бичгийн хэл	
		Тоо	Хувь (%)	Тоо	Хувь (%)
1	Уугуул үг	231,935	47.973	23,056	8.388
2	Ханз үг	160,875	33.275	164,733	59.934
3	Гадаад үг	5,922	1.225	45,663	16.613
4	Ханз үг + Гадаад үг	3,050	0.631	11,586	4.215
5	Ханз үг + Уугуул үг	79,214	16.384	28,080	10.216
7	Гадаад үг + Уугуул үг	1,215	0.251	1,262	0.459
8	Ханз үг + Гадаад үг + Уугуул үг	1,263	0.261	477	0.174
Нийт		483,474	100	274,857	100

БНСУ-ын Эх хэлний хүрээлэн 2023 оны толь бичгийн статистик⁴²

Түүнчлэн ханз үгийг таньж мэдсэнээр үгийн баялаг нэмэгдэхээс гадна орчуулгын чадвар тэр дундаа албан бичгийн орчуулгыг илүү зөв оновчтой орчуулах нөхцөл бүрддэг. Мөн тухайн хэл соёлтны ертөнцийг танин мэдсэн байдал, соёл ёс заншлын тухай өргөн мэдлэгтэй болох боломж бүрддэг. Тиймээс ч солонгос хэлний чиглэлээр суралцаж байгаа бакалаврын түвшний оюутнуудын сургалтын хөтөлбөрт солонгос хэлний ханзны хичээлийг нэгээс гурван түвшинд хуваан заахаар тусгаж өгсөн байдаг.

Энэхүү өгүүлэлдээ солонгос хэлний дөрвөн үсэгт хэлцүүдээс “хичээл зүтгэл” гэх утгатай хэлцүүдийг түүн авч тайлбар хийлээ.

№	Солонгос хэлц	Үгчилсэн орчуулга	Тайлбар	Монгол хэлний дүйцэл
1	우공이산 愚 어리석음 (мунхаг) 우 公 공평 할 (адил тэгш байх) 공 移 옮길 (нүүлгэх, зөөх) 이	Ү-Гун уул нүүлгэнэ	Хэчнээн хэцүү хэрэг байсан ч нэг зүйлийг тууштай хийвэл хэзээ нэг өдөр заавал хүссэндээ хүрнэ.	Тэнэгийг тэнгэр ивээнэ

⁴² 국립국어원(2024), 『표준국어대사전』 온라인 공식 홈페이지
<https://stdict.korean.go.kr/statistic/dicStat.do>

	山 메 (уул) 산			
Тайлбар: Энэхүү хэлц нь “Эртний Хятадад Ү-Гун гэх 90 настай өвгөн амьдардаг байжээ. Түүний амьдардаг газар эргэн тойрон өндөр уулсаар хүрээлэгдсэн байж. Тэр уулнууд нь ийш тийш явах замыг нь хаадаг байсан нь түүнийг ихэд бухимдуулдаг байсан аж. Эргэн тойрныхон нь түүнээр доог тохуу хийсэн ч тэрээр Ү-Гун тэднийг үл хайхран гэрийг нь тойрсон өндөр уулыг холдуулахын тулд үе үеэрээ уулын шороог зөөе гэсэнд бурхан түүнийг өрөвдөн тэр өндөр уулыг нь зөөж өгсөн.” гэх түүхээс эхтэй. Тодорхой түвшний солонгос хэлний мэдлэгтэй монгол хүний хувьд тухайн хэлцийг зөвхөн солонгос хэлний утга болон товч тайлбарыг хараад “Мунхаг хүнд ч гэсэн бусадтай адилхан боломж олговол, тэр ч гэсэн уулыг нүүлгэж чадна.” гэсэн утгатай дүйцэх боломжтой юм. Ийм тохиолдолд уг хэллэг монгол хэл дээр <Алагчлахгүй, ялгаварлахгүй> гэсэн утга санааг илэрхийлсэн хэллэгтэй дүйцэх болно. Мөн шантралгүйгээр шаргуу хичээвэл зорьсноо биелүүлдэг гэх санааг илтгэж байна гэж үзээд монгол хэлний “Уйгагүй хүн уул нүхэлнэ Цөхрөлтгүй хүн чөтгөр барина” гэх зүйр үгтэй дүйцүүлж болох ч хэлцийн цаад уг санаа буюу <бурхан ивээн> гэсэн санаа энэ хэлцээр бүрэн илэрхийлэгдэх боломжгүй юм. Харин уг хэллэгийн гол утга санаа нь <Заль мэх, нарийн ширийн арга сүвэгчилж чадахгүй ч гэсэн зорьсноо бүтээхийн төлөө махруу байж чадах юм бол бурхан тэнгэр тусалж зорьсныг нь бүтээнэ.> гэсэн санааг илтгэж байна.				
2	마부작침 磨 갈 (үрэх) 마 斧 도끼 (сүх) 부 作 지을 (хийх) 작 針 바늘 (зүү) 침	Сүхээ үрж зүү болгох	Хэдий хүнд хэцүү зүйл байсан ч <i>масралтгүй</i> хичээвэл заавал зорьсондоо хүрнэ.	Уйгагүй хүн уул нүхэлнэ Цөхрөлтгүй хүн чөтгөр барина
Тайлбар: Ли Бай⁴³ (701-762) эрдэм ном сурахаар одсон ч дундаас нь хаяхаар шийдээд гэр өөд буцах замдаа зүү хийхийн тулд сүхээ үрэн суугаа нэгэн эмгэнтэй таарчээ. Тэр эмгэний тууштай үйлдлээс их зүйл ухаарсан Ли Бай эргэн ууланд сууж эрдэм номд шамдсанаар их номын эзэн эзэн болжээ. Уг хэлц тууштай байдлын бас нэгэн жишээ боловч <зүрх мохохгүй байх> гэсэн цөм утгыг агуулж байна. Солонгос хэлцэд мохошгүй байдлыг тэвчээрээр харуулсан байна. Түүнчлэн тэвчээрийг урт удаан хугацаагаар илэрхийлж, урт удаан хугацаа гэх санааг сүх буюу цул төмрийг зүү болтол нь үрж дуусахад зарцуулагдах хугацаагаар илэрхийлсэн байна. Өөрөөр хэлбэл мохошгүй байхын тулд тэвчээртэй байх хэрэгтэйг сануулан бичсэн байна. Харин монгол хэлцэд мохошгүй байдлын үр дүнг илүү тодотгож өгсөн байна. Үр дүнг тодотгохдоо биелэгдэшгүй зүйл байхгүй мэтээр урамшуулах хэлбэрээр илэрхийлсэн буюу найдвараа алдахгүй бол мохохгүй байна гэсэн санаа агуулсан байна.				

⁴³ Тан улсын нэрт яруу найрагч.

3	노마십가 駕 둔한 말 (удаан морь) 노 馬 말 (морь) 마 十 열 (арав) 십 駕 멩에 (буулга) 가	Удаан морь ч хурдан морины өдрийн газрыг өдөрт нь биш юмаа гэхэд арван өдөрт туулна	Удаан, авьяас чадвар дутмаг хүн ч хичээх юм бол их хүн болж чадна.	Утсан хөрөө мод тасалж Усан дусал чулуу нүхлэнэ + Санаж явбал бүтнэ Сажилж явбал хүрнэ
Тайлбар: Тэрэг хөллөсөн морины нэг өдөрт туулах зайг “нэг буулга”-ны газар гэж хэлдэг. Тэгэхээр арван буулга гэдэг нь мориор арван өдөр туулах газрыг илтгэнэ. Монголын уламжлалт газрын хол ойрын хэмжээнээс хамгийн өргөн дэлгэр хэрэглэгддэг нь “Бээр” юм. Нэг бээр гэж 1,5-2 километр орчим газрыг хэлнэ. Монголчууд зуун бээрийн газар, мянган бээрийн газар гэх мэтээр өргөн ашигладаг. Солонгос хэлц нь субъектыг буюу туулах газар түүний хол ойрын зайг тодотгох илэрхийлэлтэй бол харин монгол хэлц нь тухайн объектын шинж чанарыг шинж чанарыг тодотгож өгчээ.				
4	여조삭비 如 같을 (адил, шиг) 여 鳥 새 (шувуу) 조 數 셈 (тоолох) 수 飛 날 (нисэх) 비	Шувуу далавчаа дэвэхгүй л бол нисэж чадахгүйн адил	Аливаа зүйлийг сайн сурахын тулд тасралтгүй давтаж дадал болгох хэрэгтэй.	Уйлсаар уйлсаар хүн Майлсаар майлсаар мал + Цаас хэдий нимгэн ч чичихээс нааш цоорохгүй Хүн хэдий ухаантай ч хэлэхээс нааш санахгүй
Тайлбар: Солонгос Монгол хэлц хоёуланд туршлагын утга илэрч байна. Монгол хэлцэд “уйлах, майлах” гэх үгээр туршлага суух гэдэг ойлголт тухайн үедээ хүнд хэцүү, амаргүй зүйл мэт санагдавч үр дүн нь эерэг байдаг гэсэн утга илэрхийлжээ. Харин солонгос хэлцэд ахин дахин давтаж туршлага суухгүй л бол сайн үр дүнд хүрэх боломжгүй буюу анхааруулах өнгө аясыг илэрхийлсэн байна. Мөн “여조삭비” хэлцэд шувуу юм чинь нисэх нь ойлгомжтой мэт боловч далавчаа хөдөлгөхгүй л бол нисэхгүй гэдэг илэрхийллээр <юмыг амар хялбар гэж бодоод нухацтай хандахгүй байвал хэчнээн амар хялбар зүйл ч биеллээ олж чадахгүй> гэсэн утга илэрч байна. Тухайн утгыг монгол хэлний “Цаас хэчнээн нимгэн ч гэсэн чичихгүй л бол цоорохгүй Хүн хэдий ухаантай ч хэлэхээс нааш санахгүй” гэсэн зүйр үгээр дүйлгэж болохоор байна.				
5	수적천석	Усны дусал чулуу цоолно	Бага багаар тасралтгүй	Дуслыг хураавал далай

	水 물 (ус) 수 滴 물방울 (дусал) 적 穿 뚫을 (цоолох) 천 石 돌 (чулуу) 석		хичээвэл их хэрэг бүтээнэ.	Дуулсныг хураавал эрдэм + Зөөлөн нь хатуугаа + Дуслах ус чулууг цоолж Зориг цөс уулыг нүхэлнэ
Тайлбар: Солонгос хэлцэд “чулуу” гэх үгээр <хүнд, бэрх>гэх санааг илтгэжээ. Гэтэл монгол хүний хувьд бол “чулуу” гэдэг зүйл сэтгэлд их ойрхон зүйл юм. Монгол хүүхдүүд багаасаа л чулуугаар тоглоом наадгай хийж өссөн байдаг⁴⁴. Монгол ахуйд зуны цагт хээр хөдөө хөл нүцгэн явах үзэгдэл бий. Тиймээс ч чулуутай ойр байж чулууг таньж мэдсэн туршлага арвин. Үүний нэг жишээ бол “тулганы гурван чулуу, овооны чулуу, нутгийн чулуу, голын чулуу, бэлийн чулуу гэх мэт чулууны талаарх олон ойлголт байдаг. Тэр ч бүү хэл “Байрнаасаа хөдөлсөн чулуу гурван жил зовдог” гэх мэтээр чулууг хайрлан өрөвдсөн илэрхийлэл ч бий. Монголчууд нутаг сэлгэж нүүхдээ гэрийн буйр дээрээ тулганы чулуугаа үлдээдэг заншилтай. Тиймээс монголчуудын хувьд чулуу гэх зүйл <тогтвортой байдал>-ыг илэрхийлдэг гэж үзэж болно. Монголчууд харин <хүнд, бэрх, хатуу ширүүн> гэх утгыг “хахир хүйтэн”- ээр зүйрлэдэг. • “ус” гэх үгээр <зөөлөн, сул, дорой> гэх утгыг зүйрлэсэн байна. “ус”, “чулуу” хоёрыг эсрэгцүүлж тавьсан нь монгол хэлний “Зөөлөн нь хатуугаа” гэх утга санаатай дүйнэ. • “дусал” гэх үгээр <өчүүхэн бага> гэдэг санааг илэрхийлсэн нь монгол хэлэн дэх “Дуслыг хураавал далай, Дуулсныг хураавал эрдэм” гэх зүйр үгийн “Дуслыг хураавал далай” буюу аливаа зүйлийг бага гэж чамлалгүй байх, өчүүхэн багаас их юм үүсдэг гэсэн утгатай дүйцнэ. • “цоолох” гэх үгээр <нэг цэгт анхаарлаа төвлөрүүлэх> гэсэн санааг илэрхийлсэн байна. • Харин монгол зүйр үгэнд “хураах” гэдэг үгээр тууштай байдлыг илэрхийлжээ. Үүнээс харахад монгол хүний хувьд амжилт гэх ойлголт “их хэрэг, том цар хүрээ”-тэй холбоотой ойлголт бол солонгос хүмүүсийн хувьд “хүнд бэрхийг давж гарах”-тай холбоотой хэрэг гэж үзэж болохоор байна.				
6	견마지로 犬 개 (нохой) 견 馬 말 (морь) 마 之 갈 (-ын) 지 勞 일할 (ажиллах) 로(노)	Морь нохойн төдий л тус	Дээдэстээ бүх чадлаа зориулсан өөрийн хүчийг даруухнаар илэрхийлсэн хэлбэр.	Морь нохой мэт зүтгэх

⁴⁴ Түдэв, Л. (1998). Хорвоотой танилцсан түүх, “Жемер” ХХК, Улаанбаатар.

Тайлбар: Энэхүү хэлц үгэнд орсон 之 갈(지) нь 가다 буюу явах очих гэсэн утгаас гадна монгол хэлний харьяалахын тийн ялгал (-ын, -ны, -ийн, -ний)-ын утгыг илэрхийлэх нь цөөнгүй.

Монгол хэлний “Морь нохой мэт зүтгэх” гэх зүйр үг туйлын үнэнчээр үйлчлэх гэсэн утгыг илэрхийлдэг. Солонгос “견마지로” зүйр үг ч дүйцлийн хувьд тун дөхөх боловч багахан ялгаатай.

Солонгос хүмүүсийн хувьд нохой гэдэг амьтан нэг талаараа үнэнч итгэмжтэй байдлыг илтгэдэг ч нөгөө талаараа хүнтэй жишигдэн үнэ хүндгүй, ашиг тусгүй гэсэн утга санааг илэрхийлдэг. Түүнчлэн солонгос хэлний үйл үгэнд ч нэр үгэнд ч “개” буюу нохой гэх утгвар авах юм бол сөрөг утга илэрхийлэх юм уу сөрөг утгын хэтрүүлэл болдог.

Жишээ нь: “꽃” буюу цэцэг гэдэг нэр үгэнд “개” утгвар ах юм бол <хоол болохгүй юм> гэсэн утга илэрхийлдэг. Учир солонгосчууд өлөн зэлмүүн явсан гашуун түүхтэй. Тухайн үед идэж болох цэцгээр хүртэл хоол хийдэг байсан ба идэж болох цэцгийг нь “참꽃” буюу “жинхэнэ цэцэг” гэж нэрлээд идэж болдоггүй цэцгийг нь “개꽃” буюу нохой цэцэг гэж нэрлэдэг байжээ. Түүнчлэн 고생하다 буюу зовох гэдэг үйл үгэнд “개” утгвар залгаж “개고생” буюу <үхтлээ зовох> гэсэн утгатай үг болох жишээтэй байдаг.

Тиймээс солонгос хэлцэд үнэнч итгэмжтэй гэхээс илүү үнэ хүндгүй, өчүүхэн гэдэг санаа туссан байна.

7	대기만성 大 클 (том) 대 器 그릇 (сав) 기 晚 늦을 (сүүлд) 만 成 이를 (бүтэх) 성	Хичээл зүтгэл, цаг хугацаа их зарж байж том сав бүтдэг	Урт удаан хугацаа, хичээл зүтгэлийн үр дүнд их хүн болдог.	Унаж байж бөх болдог + Эрийг бүү бас Далайг бүү янд
---	---	---	---	---

Тайлбар: Эртний хятадын Ви улсын Чүй ём нь хааныхаа итгэлийг хүлээсэн улсдаа нэртээ жанжин байж. Гэвч түүний үеэл дүү Им нь ах дүүдээ нэр сүргүй нэгэн байж. Харин Чүй Ём түүний төрхийг ажин хараад их хүн болох төлөвтэй хүү байна гэж хэлээд түүнийг ихэд хайрлан тусалдаг байсан гэдэг. Хожмын өдөр Им нь хааны түшмэл болсон гэдэг.

Солонгос хэлц <тийм ч амархан мундаг болчихгүй> гэсэн санааг агуулсан бөгөөд эерэг үнэлэмжтэй айна.

Дүгнэлт

Хэлний тогтвортой нэгж буюу хэлц хэллэгийг үг өгүүлбэрийн хувьд хоорондоо адил гэж үзээд дүйцүүлэн орчуулах энгийн үзэгдэл билээ. Гэвч хэлц, хэллэгийг төгс дүйцүүлэн орчуулна гэдэг бол боломжгүй хэрэг гэлтэй. Учир нь тухайн хэл-соёлтны хэлний хэрэглээ, хорвоо ертөнцийн юмс үзэгдлийг таньж мэдсэн туршлагын зөрүү буюу ертөнцийг үзэх үзлийн ялгаа, эдийн болон оюуны соёлын өвөрмөц онцлогоос үүдээд яг адилхан хоёр ойлголт ч хоёр өөр утга үнэлэмжтэй байх нь цөөнгүй.

Түүнчлэн ханзны соёлын нөлөөнд оршдог улс орнуудын хувьд ханзыг хүлээн авах, ойлгох нь ханзны соёлын нөлөөгүй улс орны хүмүүстэй харьцуулахад харьцангуй хялбар юм. Манай улс ханзны соёлгүй хэдий ч даяарчлал хийгээд боловсролын хэрэгцээ, хэл соёлын судалгааны

шаардлага гэх мэт олон шалтгаанаар хятад, солонгос, япон хэлнээс эхлээд ханзны соёлтой нүүр тулж, тодорхой түвшний мэдлэг ойлголттой болж байгаа билээ. Үүний нэг жишээгээр ханзны соёлын сонирхолтой хувилбар болох солонгос хэлний дөрвөн үсэгт хэлц үг, түүний орчуулгын тухай чадах хэмжээгээрээ судалж үзэхийг хичээлээ. Солонгос хэлний мөн ханзны соёлын сонирхолтой хувилбар гэж онцолж буй шалтгаан нь дээр дурдсанчлан Хятад улс 1964 оноос ханз үсгийн уламжлалт зурлагаа хялбаршуулсантай холбоотой. 사자성어(Sajaseong-eo) буюу солонгос хэлний дөрвөн үсэгт хэлцийн ханзны зурлагыг орчин цагийн хятад хэлэнд байхгүй эртний зурлагаар тэмдэглэдэг.

Монгол хэлний хэлц хэллэгийн санд солонгос хэлний дөрвөн үсэгт хэлцтэй утга санааны хувьд төстэй зүйр цэцэн үг, хэлц хэллэг цөөнгүй байгаа боловч хоёр орны ард түмний хэл, сэтгэлгээний онцлогоос хамаараад зүйрлэлийн нь ялгаа гарч байна. Мөн монгол хэлний хэлц хэллэгүүд ихэвчлэн хоёр мөрөөс бүтдэг бол солонгос хэлний дөрвөн үсэгт хэлц нь ихэвчлэн нэг мөрөөс бүтэж байна. Үүнээс хамаараад хоёр хэлний хэлцүүдийг дүйцүүлэн орчуулах тохиолдолд утгын илүүдэл, ташаарал гарч болохоор байна.

Солонгос хэлний ханз үгийн онцлог нь нэг дуудлага хэдэн ч утгатай байж болдог явдал юм. Жишээ нь: [공] гэдэг дуудлагатай боловч ханзны зурлагаасаа хамаараад “公” 공퍼할 (адил тэгш байх) 공; “空” 빌 (хоосон) 공; “共”함께 (хамт) “功” 공; 공 (гавьяа) 공; “紅” 상복 (гашуудлын хувцас) 공 гэх мэт өөр утгыг илэрхийлж болно. Тиймээс 사자성어(Sajaseong-eo) буюу солонгос хэлний дөрвөн үсэгт хэлцийг орчуулахдаа хамгийн эхэнд солонгос хэлний хангылъ үсгээр бичигдсэн ханз яг ямар утгатай ханз вэ гэдгийг зөв таних нь маш чухал юм. Учир нь ханзны утгыг буруу таньснаар хэлц үгийн утга бүхлээрээ өөрчлөгдөх эрсдэл үүснэ.

Түүнчлэн солонгос хэлний дөрвөн үсэгт хэлцийн дийлэнхэд нь тухайн хэлц хэрхэн үүссэн тухай эртний түүх, домог байдгаараа онцлог юм. Тиймээс орчуулга хийхдээ хэллэг үүссэн тухай домог хийгээд домогт гарч буй үйл явдал, утгыг шингээх нь нэн чухал юм.

Үүгээр зогсохгүй орчуулга хийхдээ сонгож авсан солонгос хэлний дөрвөн үсэгт хэлцтэй утга агуулгын хувьд дүйж болохуйц монгол хэлний хэлц, хэллэгүүдийг зэрэгцүүлэн тавьж аль утгаараа дүйцэж байгааг болон дүйцэхгүй байгааг нь тодруулж үзэх хэрэгтэй гэж харлаа. Жишээ нь: ““수적천석” дөрвөн үсэгт хэлцэд “чулуу” гэх үгээр <хүнд, бэрх> гэдэг санааг илтгэжээ. Гэтэл монгол хүүхдүүд багаасаа л чулуугаар тоглож өссөн байдаг. Тиймээс “чулуу” гэдэг үг ойлголтынхоо хувьд монгол хүний сэтгэлд нэлээд ойрхон зүйл бөгөөд <тогтвортой байдал> гэсэн санааг илэрхийлэх нь цөөнгүй.” гэх мэтээр утга хийгээд дүйцлийн нарийвчлалыг сайн гаргаж өгснөөр дараа дараачийн судалгаагаар солонгос хэлний дөрвөн үсэгт хэлцийн монгол орчуулгын оновчтой хувилбаруудыг дэвшүүлэх боломж бүрдэх боломж буй мэт санагдана.

Дашрамд дурдахад 사자성어(Sajaseong-eo) буюу солонгос хэлний дөрвөн үсэгт хэлцийн судалгаа шинжилгээг сайжруулснаар “Солонгос хэлний ханз”-ны хичээлийн агуулгыг улам баяжуулаад зогсохгүй задлан шинжилгээ сайн хийж өгснөөр солонгос соёлын хичээлийн хэрэглэгдэхүүн болгон ашиглаж солонгос соёл сэтгэлгээний талаарх мэдлэг ойлголтыг илүү гүн гүнзгий агуулгаар заах боломж нэмэгдээд зогсохгүй тухайн хэлний өвөрмөц онцлог бүтэц тогтолцоог тайлбарлах жишээ болгон хэрэглэх ч боломж байна.

Ном зүй

Монгол хэлээр:

1. Аким, Г. (2001). *Монгол Зүйр цэцэн үгийн товч тайлбар толь*, Улаанбаатар
2. Бат-Ирээдүй, Ж. (1987). *Монгол хэлний хэлц үгийн сан*, Улаанбаатар
3. Бат-Ирээдүй, Ж. (2005). *Зүйр цэцэн үгийн зүйлээр хуваасан толь*, Улаанбаатар
4. Бат-Ирээдүй, Ж. (2007). *Монгол хэлний хэлц үг, хэллэгийн утга, хэрэглээ*, Улаанбаатар
5. Дашням, Л, Намуун, Д. (2015). *Монгол хэвшмэл хэллэг, хэлц үгийн тайлбар толь*, Улаанбаатар
6. Нарантуяа, Ш. (2016). *Монгол хэлц үгийн тайлбар толь*, Очир пресс, Улаанбаатар
7. Тамир, Д. (2011). *Хэлц үг, зүйр цэцэн үг, оньсого 2*, “Сод пресс” ХХК, Улаанбаатар
8. Түдэв, Л. (1998). Хорвоотой танилцсан түүх, “Жемер” ХХК, Улаанбаатар
9. Отгонжаргал, О. (2011) “Зүйр цэцэн үгийг хэлний соёл судлалын үүднээс тайлбарлах нь” Монгол-Солонгос аж ахуйтай холбоотой зүйр цэцэн үгсийн харьцуулсан судалгаа
10. Эрдэнэ-Очир, Т. (2018) “Англи, Монгол хэлний зүйрлэсэн хэллэгийн утгазүйн харьцуулсан судалгаа” доктор (PhD)-ын зэрэг горилсон бүтээл

Гадаад хэлээр:

11. 범혜매. (2013). *한국 특유 사자성어의 구조에 대한 연구 The analysis of Korean Characteristic Four-Word idioms' structure*. 한양대학교
12. 양종윤. (2019). *한국어 사자성어 교육 현황과 개선*. 방안동국대학교
13. 우동. (2024). *한·중 사자성어에 나타난 문화 대조 연구 A Contrast Study on the Culture of Korean and Chinese's Four-character Idioms*. 상명대학교
14. 정가민. (2019). *사자성어를 활용한 한국문화 교육 방안 연구*. 부산외국어대학교
15. 최석두. (2015). *반드시 알아야 할 사자성어*. 시간과공간사
16. 郭儒錫. (2017). *현대 한국어의 사자성어에 대한 국어학적 연구 A Korean Linguistic Study on the Four Character Sino-Korean Frozen Expression in Contemporary Korean*. 成均館大學校
17. 鄒皓. (2014). *韓中四字成語對照研究 의미 형태 어법 A contrastive study on Korean and Chinese's four-character idioms*. 成均館大學校

Цахим эх сурвалж:

18. <https://www.naver.com/>
<https://www.wikipedia.org/>